

## НИЙГМИЙН БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2009 ОН

### **“НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ” БОЛОН “ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ” ХУУЛИУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД**

<i>Судалгааны код:</i>	СТ-09/105
<i>Судалгааны төрөл:</i>	Бодлогын судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ц.Норовдондог, Ц.Товуусүрэн, А.Пагма, Т.Мягмаржав
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн С.Бямбацогт
<i>Огноо:</i>	2009.05.12
<i>Сэдвийн агуулга:</i>	Уг судалгаа нь “Нийгмийн даатгалын тухай” болон “Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай” хуулиудын хэрэгжилтийн явцад буй болсон тулгамдсан асуудлыг тодруулж, холбогдох мэдээлэл, дүгнэлт гарган тодорхой санал, зөвлөмж боловсруулах зорилгын хүрээнд “Нийгмийн даатгалын тогтолцооны өнөөгийн байдал, цаашид сайжруулах арга зам” сэдэвт УИХ-ын дэргэдэх Бодлогын шинжилгээний төвийн 2008 онд хийсэн тайлангаас иргэдийн санал асуулгын дүн, УНДЕГ, МАОЭНХ, МҮЭХ-оос албан ёсоор авсан судалгааны, статистик, мэдээлэл, олон нийт, судлаачид, төрийн болон ТББ-ын санал, Орос, Беларус, Казахстан зэрэг улсуудын практик туршлагыг авч харьцуулан судалсан болно.

### **НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ХУУЛИУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДЛУУД**

<i>Судалгааны код:</i>	СТ-09/110
<i>Судалгааны төрөл:</i>	Бодлогын судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ц.Товуусүрэн, Т.Мягмаржав
<i>Захиалагч:</i>	УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв
<i>Огноо:</i>	2009.12.18
<i>Сэдвийн агуулга:</i>	Судалгаанд (1) “Нийгмийн халамжийн тухай” хуулиар зохицуулж буй харилцаа, гадаад орнуудын туршлага, (2) Нийгмийн халамжийн байгууллагын болон Төрийн бус байгууллагуудын өгсөн үнэлгээ, санал дүгнэлтийг нэгтгэн дүгнэснээс гадна (3) нийгмийн халамжийн үйлчилгээний судалгаа, хуулиудын хэрэгжилтийн явцад гарч буй тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийсэн.

### **ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТАЛААРХ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

<i>Судалгааны код:</i>	СТ-09/202
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ц.Норовдондог, Ц.Товуусүрэн, Ц.Товуусүрэн, Ю.Эрдэнэтуяа, Ц.Болормаа, П.Тогоо, Ц.Түвшинзаяа, Б.Мөнхцэцэг
<i>Захиалагч:</i>	Байнгын хорооны ажлын алба

**Огноо:** 2009.02.10  
**Сэдвийн агуулга:** Уг судалгаанд (1) ОХУ, Зүүн Европын улсууд болон бусад улсуудын мэргэжлийн боловсрол, сургалтын талаарх хуулийн үндсэн зарчим, бодлого агуулга хэрхэн тодорхойлогдсон, үйлчлэл, үр нөлөө болон (2) мэргэжлийн боловсролын тогтолцоо нь Боловсролын салбарт ямар байр суурь эзэлдэг, ач холбогдлыг авч үзсэн.

## **ГАДААДЫН ЗАРИМ ОРНУУДЫН ПАРЛАМЕНТИЙН ГИШҮҮДИЙН ЁС ЗҮЙН ТАЛААРХИ ЗОХИЦУУЛАЛТ**

**Судалгааны код:** СТ-09/204  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ю.Эрдэнэтуяа  
**Захиалагч:** Төрийн байгуулалтын байнгын хороо  
**Огноо:** 2009.04.20  
**Сэдвийн агуулга:** Судалгааны эхний хэсэгт Австри, Их Британи, ХБНГУ, Энэтхэг, Умарт Ирланд, Канад, АНУ, Өмнөд Солонгос, Польш, Литви, ОХУ, Бельги зэрэг орнуудын парламентын гишүүдийн ёс зүйн асуудлаарх нийтлэг зохицуулалтын хүрээнд эрх зүйн акт, ёс зүйн асуудал хариуцсан бүтэц, хариуцлага тооцох механизм зэрэг асуудлуудыг хамруулсан. Судалгааны дараагийн хэсэгт дээрх орнуудын ёс зүйн зарим хэм хэмжээний талаарх зохицуулалтын хүрээнд ашиг сонирхлын зөрчил, давхар ажил эрхлэлт, бэлэг дурсгал зэрэг асуудлуудыг хамруулсан.

## **ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ АСУУДАЛ, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА**

**Судалгааны код:** СТ-09/216  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Т.Мягмаржав  
**Захиалагч:** УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв  
**Огноо:** 2009.11.04  
**Сэдвийн агуулга:** Судалгаанд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн төсөлд шинжилгээ хийх, энэхүү асуудлыг Япон, Хятад, Норвеги, Австрали, Дани, Швед зэрэг орнуудад хэрхэн зохицуулагдаж байгааг шинжлэн судалсан болно.

## **ТӨРӨӨС ДЭЭД БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ҮЗҮҮЛЖ БҮЙ ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА, ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГИЙН АСУУДЛААРХИ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

**Судалгааны код:** СТ-09/220  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ц.Норовдондог, Ц.Товуусүрэн, Ц.Болормаа, Д.Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, О.Нарантуяа  
**Захиалагч:** УИХ-ын Тамгын газрын Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв  
**Огноо:** 2009.12.10  
**Сэдвийн агуулга:** Судалгаанд Монгол Улсад дээд боловсролын салбарт үзүүлж буй төрийн дэмжлэг туслалцааны асуудлыг 1992 оноос хойш зохицуулж байсан эрх зүйн баримт бичиг болоод өнөөг хүртэл хүчин төгөлдөр

үйлчилж буй эрх зүйн баримт бичгүүдийг хамруулсан болно. Түүнчлэн манай улсын төсвөөс 1994-2008 оны хооронд оюутны тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл, тусламжид зарцуулсан хөрөнгийн статистик мэдээллийг дэмжлэг, туслалцааны хэлбэр бүрээр харьцуулан үзүүлсэн юм.

Судалгаанд хамруулсан улс орнуудыг сонгохдоо тухайн орны хөгжлийн үзүүлэлт, сургалтын зээл болон бусад дэмжлэгийн талаарх туршлагыг амжилттай хэрэгжүүлсэн туршлага, түүнчлэн сургалтын чанарын үзүүлэлт зэрэг шалгууруудыг голлон өндөр хөгжилтэй орон, Азийн орон, хуучин социалист зэрэг орнуудыг бүлэглэн авч үзсэн юм. Өндөр хөгжилтэй улс оронд Австрали, Их Британи, Турк, Швед, хуучин социалист орнуудад Орос, Казахстан, Беларус, Азийн орнуудад Энэтхэг, Япон, Солонгос зэрэг улс орныг багтаан тэдгээрийн холбогдох хууль, журмуудыг Монгол Улсын хууль, холбогдох журмуудтай харьцуулан судалсан болно.

### **МОНГОЛ УЛС ДАХЬ ТАМХИНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ ЦААШИД ТАМХИНЫ ХЭРЭГЛЭЭГ БУУРУУЛАХ АСУУДЛЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ**

<i>Судалгааны код:</i>	СТ-09/312
<i>Судалгааны төрөл:</i>	Тойм судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ч.Онончимэг, Д.Золбоо, Ц.Элбэгзаяа, О.Нарантуяа
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн С.Оюун
<i>Огноо:</i>	2009.12.10
<i>Сэдвийн агуулга:</i>	Уг тойм судалгаанд Монгол Улс дахь тамхины хэрэглээ, тамхин бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импортын өнөөгийн байдал, Тамхины талаарх бодлогын баримт бичиг, төрийн хяналт, Тамхины талаарх бодлогын баримт бичиг, төрийн хяналт зэрэг асуудлуудыг хөндсөн. Тухайлбал, импортоор нийлүүлж буй тамхины чанар, хуурамч тамхи, зах зээл дээр борлогдож буй тамхины нэр төрөл болон тамхи импортлогч компаниудын мэдээлэл, дотоодын зах зээлд борлогдож буй тамхинд агуулагдах хорт бодисын хэмжээ, тамхины хяналтын талаарх бодлогын баримт бичгүүд, тамхин бүтээгдэхүүний стандарт, тээвэрлэлт болон хадгалалтанд тавигдах шаардлага, татвар, тамхины зар, сурталчилгааны зэрэг асуудлууд багтсан байна.

### **ТӨРИЙН САНГИЙН ЗЭЭЛЭЭР ӨНДӨР ХӨГЖИЛТЭЙ ОРНУУДАД СУРАЛЦАГЧДЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ СУДАЛГАА**

<i>Судалгааны код:</i>	СТ-09/404
<i>Судалгааны төрөл:</i>	Мэдээлэл лавлага
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ц.Товуусүрэн, П.Тогоо
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Х.Тэмүүжин
<i>Сэдвийн агуулга:</i>	Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар төрийн сангийн хөрөнгөөр дээд боловсрол эзэмшүүлэх журмыг Засгийн газар тогтоохоор заасны дагуу 2008.05.14-ний өдрийн 177-р тогтоолоор Сургалтын төрийн сангийн хөрөнгийг захиран зарцуулах журам, Монгол Улсын болон гадаадын дээд боловсролын байгууллагад суралцагчдад төрийн буцалтгүй тусламж олгох журам, Гадаадын дээд боловсролын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журмыг тус тус баталсан байна. Эдгээр журмууд батлагдан гаргаснаас хойш 2001-2008 онд

өндөр хөгжилтэй орнуудад сургасан суралцагчдын талаарх мэдээллийг оруулсан болно.

## 2010 ОН

---

### **МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ ЗҮЙН БОДЛОГО БА ХӨГЖЛИЙН АСУУДАЛ, НӨЛӨӨЛЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛИЙН ШИНЖИЛГЭЭ**

<i>Судалгааны код:</i>	СТ-10/106
<i>Судалгааны төрөл:</i>	Бодлогын судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ц.Болормаа, Б.Мөнхцэцэг, О.Нарантуяа, Ө.Мөнхтунгалаг, Т.Мягмаржав, А.Пагма, Ч.Онончимэг, Ц.Элбэгзаяа
<i>Захиалагч:</i>	УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв
<i>Огноо:</i>	2010.11.29
<i>Сэдвийн агуулга:</i>	Төрөөс баримталж буй хүн ам зүйн бодлогын хэрэгжилтийн явцад буй болсон тулгамдсан асуудлыг тодруулж, холбогдох мэдээлэл, дүгнэлт гарган тодорхой санал, зөвлөмж боловсруулах зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн судалсан болно. Үүнд: <ul style="list-style-type: none"><li>- Монгол Улсын хүн ам зүйн болон хүний хөгжлийн үзүүлэлтүүдийн динамик судалгаа,</li><li>- Монгол Улсын хүн ам зүйн бодлогын тулгамдсан асуудлыг тодорхойлох</li><li>- Монгол Улсын хүн ам зүйн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх</li><li>- Хүн ам зүйн талаар гадаадын зарим орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, эрх зүйн орчин, туршлагыг харьцуулан судлах,</li><li>- Монгол Улсын иргэн, харьяатын асуудалтай холбоотой эрх зүйн орчин, тулгамдсан асуудлыг судлах,</li><li>- Монгол Улсын хүн амын өсөлтийн коэффициент түүнд нөлөөлсөн хүчин зүйлийн шинжилгээ, 2009-2050 оны хүн амын өсөлтийн прогноз болон хүн амын өсөлт ба эдийн засгийн хөгжлийн хамаарал зэрэг асуудлуудыг судалсан болно.</li></ul>

### **НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

<i>Судалгааны код:</i>	СТ-10/107
<i>Судалгааны төрөл:</i>	Бодлогын судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Ц.Товуусүрэн, А.Пагма
<i>Захиалагч:</i>	УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв
<i>Огноо:</i>	2010.11
<i>Сэдвийн агуулга:</i>	Судалгаанд (1) Нийгмийн даатгалын харилцааг зохицуулж буй эрх зүйн орчны тойм мэдээлэл, лавлагааны хүрээнд (1.1) салбарын бодлогыг тодорхойлж буй баримт бичгүүд, (1.2) Монгол Улсын хуулиуд, (1.3) хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүд, (2) нийгмийн даатгалын хуулиудын хэрэгжилтийн өнөөгийн байдалд хийсэн үнэлгээний хүрээнд (2.1) хуулиудын хэрэгжилтийн талаарх олон нийтийн үнэлгээ, санаа бодол, (2.2) судалгааны байгууллага, судлаачдын хийсэн үнэлгээ, санал, зөвлөмж, (3) нийгмийн даатгалын сангуудын хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хийсэн

шинжилгээний хүрээнд (3.1) сангуудын орлого, зарлага, хөрөнгийн үлдэгдэл, (3.2) сангуудын чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн ашиглалт, (4) Гадаадын зарим орнуудын тэтгэврийн даатгалын тогтолцоо, (5) Нийгмийн даатгалын тухай хуулиудын хэрэгжилтийн явцад гарч буй тулгамдсан асуудлууд, хэрхэн шийдвэрлэх талаарх санал, зөвлөмж зэрэг сэдвийн хүрээнд судалсан. Түүнчлэн гадаадын зарим орны (Беларус, ОХУ, Казахстан) нийгмийн даатгалын сангийн бүрдүүлэлтийн харьцуулсан судалгааг хавсаргасан.

## **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭРХ СУДАЛГААНУУДЫН ҮР ДҮН**

*Судалгааны код:* СТ-10/219  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Товуусүрэн, А.Пагма, Б.Мөнхцэцэг, Т.Мягмаржав, Б.Ариунжаргал, Б.Хатантуул  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Д.Тэрбишдагва  
*Огноо:* 2010.07.07  
*Сэдвийн агуулга:* Энэхүү судалгаа нь хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, яам, агентлаг, нийслэл, дүүрэг, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагуудаас гаргасан судалгаа шинжилгээний мэдээлэл, дүгнэлт, зөвлөмж, бодлогын баримт бичгүүдийг харьцуулан дүн шинжилгээ хийж, цаашид энэ чиглэлийн бодлого, хөтөлбөр, эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар зөвлөмж боловсруулах зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газраас гаргасан бодлогын баримт бичгийг судлах,
- Судалгааны сэдвээр Засгийн газар, олон улсын байгууллага болон эрдэм шинжилгээний байгууллагаас гаргасан судалгааны тайлан, материалд шинжилгээ хийх,
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх асуудлаар ТББ-аас хийсэн судалгааны тайлан, материалыг судлах.

## **ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДЫН САНХҮҮЖИЛТ, ТӨРӨӨС ҮЗҮҮЛЖ БУЙ ДЭМЖЛЭГ, ОЮУТАН-СУДЛААЧДАД ОЛГОДОГ ТЭТГЭЛЭГ /СТИПЕНДИ/, ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШДАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-10/221  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Судалгааг удирдсан:* Ц.Норовдондог  
*Гүйцэтгэсэн судлаач:* П.Амаржаргал, Ц.Болормаа, Д.Живгаагүнсэл, Г.Гэрэл, Ө.Мөнхтунгалаг, О.Нарантуяа  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв  
*Огноо:* 2010.11.08  
*Сэдвийн агуулга:* Энэхүү судалгаа нь Судалгааны төвөөс өмнө нь гүйцэтгэсэн” Төрөөс боловсролын салбарт үзүүлэх дэмжлэг тусалцаа, оюутны

тэтгэлгийн асуудлаарх бусад орнуудын туршлага, эрх зүйн зохицуулалт” харьцуулсан судалгааны 2-р хэсэг буюу үргэлжлэл юм.

Судалгааны зорилго: Олон улсын байгууллагын зөвлөснөөр, аль ч улс орон төсвийн хөрөнгийнхөө тодорхой хувийг зайлшгүй дээд боловсролын санхүүжилтэд хуваарилах ёстой бөгөөд “Боловсролын салбарт төрөөс оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ нь ДНБ-ны 4-6 хувь байх ёстой. Үүнээс их, дээд сургуулиудад зарцуулах хөрөнгө нь боловсролын салбарт зарцуулж буй хөрөнгийн 15-20 хувь байх шаардлагатай” гэсэн нийтлэг зөвлөмж байдаг.

Үүнтэй уялдуулан төрөөс дээд боловсролын салбарт оюутны амьдрах, сурах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн стипенд, зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламж зэрэг санхүүгийн дэмжлэг ямар байдаг талаарх бусад орнуудын туршлагыг харьцуулан судлав

## **ЗАСГИЙН ГАЗРУУДЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ НИЙГМИЙН БОДЛОГЫН АСУУДЛЫГ ХЭРХЭН ТУСГАСАН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН МЭДЭЭЛЭЛ**

*Судалгааны код:* СТ-10/222

*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа

*Гүйцэтгэсэн судлаач:* Ч.Базар, С.Дорждагва, Б.Мөнхцэцэг, Ө.Мөнхтунгалаг

*Захиалагч:* УИХ-ын гишүүн Д.Очирбат

*Огноо:* 2010.10.11

*Сэдвийн агуулга:* Энэхүү харьцуулсан мэдээллээр 1996-2012 оны хоорондох Засгийн газруудын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан нийгмийн бодлогын асуудлуудыг “Хүн ам, нийгмийн хамгаалал”, “Эрүүл мэнд”, “Боловсрол”, “Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл”, “Ядуурал” гэсэн хэсгүүдэд хуваан ангилж, зарим харьцуулалтыг хийв. Хавсралт 2-д Нийгмийн бодлогын талаарх судалгааны танилцуулга, хэвлэлийн нийтлэлийг тоймлов.

---

## **2011 ОН**

### **ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙН ХАМГААЛАХ ЧИГЛЭЛИЙН [ЗАСГИЙН ГАЗРЫН БУС] БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ**

*Судалгааны код:* СТ-11/205

*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа

*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Норовдондог, Т.Мягмаржав, Г.Чулуун, Ө.Мөнхтунгалаг, Н.Түвшинтөгс

*Захиалагч:* УИХ-ын гишүүн Н.Ганбямба

*Огноо:* 2011.02.10

*Сэдвийн агуулга:* Судалгааны ажилд АНУ, Швед, Их Британи, Монгол Улс, Турк, Ирланд, Солонгос, Герман зэрэг улсууд болон Европын Холбооны хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлд гарсан болон гарч байгаа туршлагыг харьцуулан судалсан.

## **ЭНГИЙН ИРГЭД БОЛОН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТЭТГЭВЭР ТЭТГЭМЖИЙН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

*Судалгааны код:* СТ-11/218  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Товуусүрэн, П.Амаржаргал, Б.Мөнхцэцэг, Б.Хатантуул, А.Пагма  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Д.Ганхуяг  
*Огноо:* 2011.06.30  
*Сэдвийн агуулга:* Энэ судалгаанд Монгол Улсын энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамж үйлчилгээний талаархи өнөөгийн байдал, мөн ОХУ, БНКаЗУ, Швед, Чех, Япон улсын холбогдох хуулиудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр тэтгэмж, нийгмийн хамгааллын талаар хэрхэн зохицуулсаныг судлав.

## **ЯСЛИ, ЦЭЦЭРЛЭГИЙН ТОО БОЛОН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН БУС ӨМЧИТ ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН ТӨЛБӨРИЙН ТАЛААРХ СУДАЛГАА**

*Судалгааны код:* СТ-11/224  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Т.Мягмаржав  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн, НББСШУБХ-ны дарга Д.Очирбат  
*Огноо:* 2011.10.24  
*Сэдвийн агуулга:* БСШУЯ-аас гаргасан 2011-2012 оны хичээлийн жилийн урьдчилсан мэдээгээр нийт улсын хэмжээнд 880 цэцэрлэг байгаагийн 735 нь төрийн өмчит, 145 нь төрийн бус өмчит цэцэрлэг тус тус ажиллаж байна. 2008 оноос хойш нийт 101 цэцэрлэгийн барилгыг шинээр барьж, орны тоог 8355-аар нэмэгдүүлсэн. Хөдөөгийн баг бүрийг гэр цэцэрлэгтэй болгоход анхаарч одоогийн байдлаар нийт багийн 50 хувьд буюу 600 багт гэр цэцэрлэг ажилласан бөгөөд 2011 онд 200, ирэх онд 200 гэр цэцэрлэг нэмж ажиллуулахаар төлөвлөжээ.  
2010-2011 оны хичээлийн жилийн эхний хагас жилийн байдлаар Нийслэлийн хэмжээнд Ерөнхий боловсролын төрийн өмчит сургууль 75, Ерөнхий боловсролын төрийн бус өмчит сургууль 72 хичээллэж байна. Төрийн өмчийн их, дээд сургууль 14 хичээллэж байгаа, орон нутагт 3 салбартай, төрийн бус дээд сургууль нь 55 түүнээс орон нутагт 2 салбартай, төрийн өмчийн бус коллеж 23 байгаагийн орон нутагт 3, гадаадын их сургуулийн 5 салбар байдгаас орон нутагт 1 тус тус үйл ажиллагаагаа явуулж байна.

## **ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН БИЕ ДААСАН ТОГТОЛЦОО: ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛИНД ХЭРХЭН ТУСГАСАН БАЙДАЛ, ХУУЛЬ ЗҮЙН ҮР ДАГАВАР**

*Судалгааны код:* СТ-11/401  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ч.Базар  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв  
*Огноо:* 2011.01.04  
*Сэдвийн агуулга:* Лавлагаа мэдээлэлд ЭМД-ын байгууллагын тогтолцоог ИЭМД-ын хуулийн шинэчилсэн төсөлд тусгасан байдал, хууль зүйн үр дагавар, ЭМД-ын тогтолцоог шинэчлэх шаардлага, тулгамдаж буй асуудал,

шийдвэрлэх арга зам, ИЭМД-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх экспертүүдийн санал, бусад орны туршлага: давуу болон сул тал болон нэмэлт мэдээлэл буюу эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилтийн өнөөгийн байдал зэрэг мэдээллийг багтаасан бөгөөд ЭМД-ын талаарх сүүлийн үеийн судалгаа, зохион байгуулагдсан хурлын илтгэл, ИЭМД-ын тухай хуулийн төсөлд шинжилгээ хийсэн зөвлөхүүдийн дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг харьцуулах замаар бэлтгэв.

## **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИНД ЭНГИЙН ИРГЭД БОЛОН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТАЛААР ТУСГАСАН БАЙДАЛ**

*Судалгааны код:* СТ-11/406  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Товуусүрэн, П.Амаржаргал, Б.Мөнхцэцэг, А.Пагма, Б.Хатантуул  
*Захиалагч:* УИХ-ын Тамгын газрын Нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн  
*Огноо:* 2011.04.04  
*Сэдвийн агуулга:* Лавлагаа мэдээлэлд (1)ЭМД-ын байгууллагын тогтолцоог ИЭМД-ын хуулийнЕвроп, Азийн зарим орнуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаарх эрх зүйн зохицуулалт, (2)энгийн иргэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар Монгол Улсын “Хөдөлмөр эрхлэлтийн тухай” хуулиудад хэрхэн тусгасан тухай харьцуулалт, (3)Монгол Улс, ОХУ,Япон, Швед, БНКУ, БНЧУ-ын хөдөлмөр эрхлэлтийн хуулийн энгийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаарх эрх зүйн зохицуулалтын харьцуулалтыг оруулсан.

## **ОЮУН УХААНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД БОЛОВСРОЛ ОЛГОХ ТОГТОЛЦОО, СТАНДАРТ, ТӨСӨВ САНХҮҮЖИЛТ, БАГШЛАХ БОЛОВСОН ХҮЧНИЙ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО**

*Судалгааны код:* СТ-11/411  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар, А.Пагма, Ч.Базар, Б.Дуламсүрэн, Б.Мөнхцэцэг  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн С.Оюун  
*Огноо:* 2011.06.07  
*Сэдвийн агуулга:* Энэхүү судалгаагаар оюун ухааны хомсдлын тухай ерөнхий ойлголт, оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсрол эзэмших асуудлын эрх зүйн зохицуулалт, тэдэнд боловсрол олгох тогтолцоо, түүний шатлал, сургалт болон боловсролд баримтлаж байгаа стандарт, боловсролын байгууллагын багшлах боловсон хүчин, төрөөс баримтлаж байгаа бодлого, хөдөө орон нутагт амьдардаг оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролд хамрагддаг эсэх, сурч боловсроход улсаас зарцуулж буй төсөв, тэдэнтэй ажиллаж буй багш, сурган хүмүүжүүлэгч нарын цалин, орлого зэрэг өргөн хүрээний асуудлуудыг хамруулан судалсан.



## **ТЭТГЭВРИЙН НЭРИЙН ДАНСЫГ ӨВЛҮҮЛДЭГ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

**Судалгааны код:** СТ-11/412  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Б.Ариунжаргал, Т.Мягмаржав  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн З.Алтай  
**Огноо:** 2011.06.22  
**Сэдвийн агуулга:** Судалгааг захиалгын дагуу Тэтгэврийн нэрийн дансыг өвлүүлдэг бусад улс орнуудын туршлага, хууль эрх зүйн зохицуулалтын талаар Герман, Япон, Эстони, Украин улсын туршлагаас судалсан болно. Нийгмийн даатгал гэдэг нь төрийн нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх механизм, хүн амын нийгмийн хамгааллыг зохион байгуулах үндэс юм. Энэ тогтолцоо нь дэлхий нийтийн практикт зохион байгуулалтын хувьд а) улсын нийгмийн даатгал (заримдаа төвлөрсөн даатгал гэдэг), б) хамтын даатгал (төвлөрсөн бус даатгал), в) холимог даатгал, г) хувийн даатгал гэсэн хэлбэртэй байдаг байна.

## **ЦЭРГИЙН ТЭТГЭВЭР БОЛОН НЭГ УДААГИЙН ТЭТГЭМЖ АВСАН ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧДЫН ТАЛААРХ СУДАЛГАА**

**Судалгааны код:** СТ-11/413  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Б.Мөнхцэцэг, А.Пагма, Б.Хатантуул  
**Захиалагч:** УИХ-ын Тамгын газрын Судалгааны төв  
**Огноо:** 2011.06.28  
**Сэдвийн агуулга:** Судалгаанд Монгол Улсын Зэвсэгт хүчин болон Хил хамгаалах Ерөнхий газрын хэмжээнд “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуулийн дагуу цэргийн албан хаагчийн нэг удаагийн тэтгэмж авсан хүний тоо, түүний дотор 2000 оноос өмнө уг тэтгэмжийг авсан хүний тоог нэгтгэн гаргасан.

## **МОНГОЛ УЛСЫН ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БОЛОН ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ**

**Судалгааны код:** СТ-11/501  
**Судалгааны төрөл:** Дүн шинжилгээ  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ч.Онончимэг, О.Нарантуяа, Ц.Элбэгзаяа  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн А.Тлейхан  
**Огноо:** 2011.01.07  
**Сэдвийн агуулга:** Дүн шинжилгээний Монгол Улсын тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал гэсэн эхний хэсэгт Монгол Улсын тамхины хяналтын тухай хууль болон бусад эрх зүйн зохицуулалт, Тамхины хяналтын тухай хуульд хяналтын болон хариуцлагын зохицуулалтыг хэрхэн тусгасан, тамхины хяналтын тухай хууль хэрэгжихгүй байгаа шалтгаан нөхцөлийг дурьдсан. Дараагийн хэсэгт Орос, Турк, Англи, Япон, Испанизэрэг орнуудын тамхины хяналтын эрх зүйн зохицуулалтын талаарх туршлагыг судалсан ба сүүлийн хэсэгт Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хийсэн шинжилгээг хийсэн.

## **ХАРАА ХЯНАЛТГҮЙ ХҮҮХДҮҮДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ ЭКСПЕРТИЙН САНАЛ АСУУЛГЫН СУДАЛГААНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭ**

*Судалгааны код:* СТ-11/502  
*Судалгааны төрөл:* Дүн шинжилгээ  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ц.Товуусүрэн, А.Пагма болон Судалгааны төвийн 23 судлаачид  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн А.Тлейхан  
*Огноо:* 2011.01.21  
*Сэдвийн агуулга:* Монголын ирээдүй болсон хүүхдийн талаар төрөөс баримтлах бодлогыг боловсронгуй болгох, ялангуяа хараа хяналтгүй хүүхдүүдийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар энэ асуудлыг хариуцан ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудын ажилтнуудын саналыг авч нэгтгэн боловсруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

Судалгааг Улаанбаатар хотод явуулах бөгөөд НХХЯ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө газар, Нийслэлийн хүүхдийн төлөө газар, Нийслэлийн хүүхдийн халамж, үйдчилгээний газар, Нийслэлийн цагдаагийн газар, дүүргүүдийн цагдаагийн газар, Хүүхдийн хаяг тогтоох төв, нийслэлийн зарим хороод, хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын тус асуудлыг хариуцсан ажилтнууд хамрагдана. Экспертийн түвшинд анкет асуулгын аргыг судалгаанд хэрэглэсэн.

## **2012 ОН**

---

### **ҮНДЭСНИЙ УЛААН ЗАГАЛМАЙН НИЙГЭМЛЭГҮҮДЭД ТӨР, ЗАСГИЙН БАЙГУУЛЛАГААС ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛДЭГ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА**

*Судалгааны код:* СТ-12/206  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Д.Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаг  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Н.Энхболд  
*Огноо:* 2012.04.26  
*Сэдвийн агуулга:* Гадаадын зарим орны үндэсний улаан загалмайн нийгэмлэгүүдийн албан ёсны вэб сайт, хууль эрх зүйн актууд, судалгааны материал, Монголын улаан загалмайн нийгэмлэгийн холбогдох эрх бүхий мэргэжилтнүүдээс ирүүлсэн мэдээлэл зэргийг эх сурвалж болгон Финлянд, Польш, БНСУ, БНХАУ, Япон зэрэг орнуудын Үндэсний улаан загалмайн нийгэмлэгүүдэд төр засгийн байгууллагаас хэрхэн дэмжлэг үзүүлдэг талаар мэдээллийг харьцуулан судалсан болно.

### **ҮНДЭСНИЙ ХЭЛЭЭ ТӨРИЙН АЛБАН ЁСНЫ ХЭЛ БОЛГОН АШИГЛАХ ТАЛААР МОНГОЛ УЛС БОЛОН БУСАД ОРНЫ БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ”**

*Судалгааны код:* Код: СТ-12/224  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Д.Живгаагүнсэл  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Н.Батцэрэг

**Огноо:** 2012.11.02  
**Сэдвийн агуулга:** Уг судалгааг БНХАУ, Франц, Казахстан улс, АНУ, Монгол зэрэг улсуудын Төрийн албан ёсны хэлний талаар баримталж байгаа бодлого, эрх зүйн зохицуулалтын тухай туршлагыг Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, мэдээлэл, судалгааны материалд үндэслэн хийсэн болно. Мөн Монгол Улсын төрийн албан ёсны хэлний бодлого, түүхэн уламжлал, хууль эрх зүйн зохицуулалт, өнөөгийн байдлын талаар судалж судалгааны дүгнэлт бичиж, хэлний бодлогыг харьяалж буй байгууллагуудын талаарх жагсаалтыг хавсаргав.

### **МОНГОЛЫН ЭМЭГТЭЙ УЛС ТӨРЧИД**

**Судалгааны код:** СТ-12/403  
**Судалгааны төрөл:** Мэдээлэл лавлагаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Т.Мягмаржав  
**Захиалагч:** Судалгааны төв  
**Огноо:** 2012.05.17  
**Сэдвийн агуулга:** Монгол Улс 1990 онд байнгын ажиллагаатай парламенттай болсоор эдүгээ 20 гаруй жил болов. Энэ хугацаанд нэр бүхий 19 эмэгтэй хууль тогтоох дээд байгууллагад ажилласан байна. Ялангуяа УИХ-ын сүүлийн 2 сонгуульд энэ тоо буурч ердөө 3 эмэгтэй сонгогдсон нь улсын нийт хүн амын 52 хувийг эмэгтэйчүүд эзэлдэгтэй харьцуулбал хэтэрхий бага үзүүлэлт юм. Түүнчлэн гүйцэтгэх эрх мэдлийн талбарт үзэгдэхүйц эрх мэдэл бүхий албан тушаал хашдаг эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 6,6 хувь байгаа нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байгааг харуулж байна. Эмэгтэйчүүд парламентад аль болох олноор сонгогдох нь төрийн захиргааны албан хаагчдын 46 хувийг, төрийн үйлчилгээний 72 хувийг эзэлдэг нийт эмэгтэйчүүдийн болон дунд, доод шатны ажлын дийлэнхийг нугалдаг эмэгтэйчүүдэд анхаарлаа хандуулах, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлүүлэх, тодорхой өөрчлөлтүүдийг хийх зэрэг олон талын ач холбогдолтой юм.

### **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ТОГТООМЖУУДЫН ӨӨРЧЛӨЛТТЭЙ ХОЛБООТойГООР БОЛОВСРОЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ БОЛОН ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ САЛБАРТ ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭ**

**Судалгааны код:** СТ-12/502  
**Судалгааны төрөл:** Дүн шинжилгээ  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ц.Норовдондог (Ph.D), Ц.Товуусүрэн, Б.Мөнхцэцэг, Т.Мягмаржав, Ч.Онончимэг, А.Пагма  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Х.Бадамсүрэн  
**Огноо:** 2012.03.15  
**Сэдвийн агуулга:** 2008-2012 онд Нийгмийн хамгааллын салбарын хөгжил, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, үр дүн /нийгмийн даатгалын хамрагдалт, нийгмийн даатгалын сангийн орлогын бүрдүүлэлт, зарлага, зарлагын төрөл, нийгмийн халамж/, боловсролын салбарын эрх зүй, нийгэм, эдийн засгийн талаар авсан арга хэмжээнүүд, эрүүл мэндийн салбарын хууль, эрх зүйн орчин, нийгэм, эдийн засгийн өөрчлөлт болон эдийн засгийн салбарын хууль тогтоомжийн өөрчлөлттэй холбоотойгоор эдийн засгийн зарим салбарт гарсан үр дүнг

харуулжээ. Энэхүү судалгааны ажлыг УИХ-аар 2008-2012 оны хугацаанд батлагдсан хууль тогтоомжууд, тэдгээрийн өөрчлөлтийн хүрээнд гүйцэтгэсэн болно.

## 2013 ОН

---

### **ТЭТГЭВРИЙГ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДЭД НЬ ӨВЛҮҮЛЭХ НӨХЦӨЛ, ЖУРМЫН ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ЗОХИЦУУЛАЛТ**

**Судалгааны код:** СТ-13/202  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ц.Товуусүрэн, А.Пагма, Ө.Мөнхтунгалаг, Д.Живгаагүнсэл  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн С.Эрдэнэ  
**Огноо:** 2013.01.22  
**Сэдвийн агуулга:** Уг судалгаагаар Монгол Улсын гэр бүлийн статистик тоо баримтыг Улсын бүртгэлийн газар, Үндэсний статистикийн хорооноос гаргасан баримтат тулгуурлан гаргаж, боловсруулалт хийж, 10-аас дээш жил хамтран тогтвортой амьдарсан нийт гэр бүлийн тоо, бэлэвсэн гэр бүлийн тоог нэгтгэн гаргасан бөгөөд Өндөр насны тэтгэврийг өвлүүлдэг гадаадын улс орнуудын туршлагыг судалснаар тэтгэврийн тогтолцоог шинэчлэх бодлогыг тодорхойлоход анхаарвал зохих асуудлыг тодруулсан болно. Тухайлбал судалгаанд *Чили, Швед, Итали, ОХУ, АНУ, Их Британи зэрэг өндөр хөгжилтэй орнуудыг хамрууллаа.*

### **ХҮҮХЭД АСАРСНЫ ТЭТГЭМЖ ОЛГОХТОЙ ХОЛБОГДСОН СТАТИСТИК ТОО БАРИМТ, ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

**Судалгааны код:** СТ-13/208  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ц.Товуусүрэн, А.Пагма, Ө.Мөнхтунгалаг, Д.Живгаагүнсэл  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат  
**Огноо:** 2013.02.01  
**Сэдвийн агуулга:** Судалгаанд Монгол улсад Хүүхэд асарсны тэтгэмж олгох талаар шийдвэр гаргахад улсын төсвийн зардалд нөлөөлөх нөлөөллийг статистик тоон мэдээлэл судалгаанд суурилан тооцож гаргасан бөгөөд хүүхэд асарсны тэтгэмжийг хэрхэн ямар хууль эрх зүйн зохицуулалтаар хэрхэн ямар журмаар олгодог тухай гадаадын зарим орны туршлагыг судалсан болно. Тухайлбал судалгаанд Нидерланд, Чех, Узбекистан, ОХУ зэрэг орнуудыг хамруулсан.

### **ХҮҮХДИЙН ӨМЧЛӨЛ, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

**Судалгааны код:** СТ-13/213  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Р.Хатанбаатар, А.Пагма, Д.Живгаагүнсэл, Г.Гэрэл

**Захиалагч:** УИХ-ын гишүүн Д.Оюунхорол  
**Огноо:** 2013.03.06  
**Сэдвийн агуулга:** Хүүхдийн өмчлөл, эд хөрөнгийн эрхийг хамгаалах асуудлын эрх зүйн зохицуулалтыг зарим орны тухайлбал, Канад, Швед, Украин, Хятад, Литва, Хонконг, Финландын зохих хууль эрх зүйн орчныг судлан жишээн харьцуулан гаргасан.

#### **ХҮН АМЫН ОРОН СУУЦНЫ ХАНГАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА МЕХАНИЗМ, ТӨРӨӨС ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ: БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА**

**Судалгааны код:** СТ-13/217  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ц.Норовдондог (Ph.D), Г.Билгээ  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн М.Зоригт  
**Огноо:** 2013.04.11  
**Сэдвийн агуулга:** Боломжтой нөхцөлөөр олон өрх айлыг орон сууцаар хангахын тулд бусад орны төр, засгаас ямар дэмжлэг үзүүлдэг, ямар бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа талаар гадаадын зарим орны туршлага, холбогдох эрх зүйн орчныг харьцуулан судалж үзлээ.

#### **ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛ**

**Судалгааны код:** СТ-13/218  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ц.Товуусүрэн, А.Пагма, Д.Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаг  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Д.Ганхуяг  
**Огноо:** 2013.04.11  
**Сэдвийн агуулга:** Судалгааны зорилго нь гадаадын зарим улс орнуудын эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн байдал, эрүүл мэндийн салбар дахь хувийн хэвшлийн оролцоо, эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийн онцлог зэргийг судалж, бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд анхаарвал зохих асуудлуудыг тодруулахад чиглэгдсэн.

#### **НИЙТИЙН БА НИЙТИЙН БУС ТООЛЛЫН ШИНЭ ЖИЛИЙН БАЯРЫН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ**

**Судалгааны код:** СТ-13/219  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Г.Чулуун  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Су.Батболд  
**Сэдвийн агуулга:** Захиалагчийн хүсэлтэд дорнын давхар тоололтой Ази тивийн нэр бүхий улс орнуудын цагаан сарын баярын [хууль ёсоор] үргэлжлэх хугацааны болон, мөн түүнчлэн, Христосын мэндэлсэн өдрөөр, ер нь он угтах “шинэ жилийн баярууд” –аар европын орнуудад “бүх нийтээр хэчнээн хоног амардаг” талаар лавлагаа тодруулга авах тухай дурдсан. Энд, хөндсөн асуудлын мөн чанар нь, дэлхийн улс орнуудад [янз бүрийн хуанлийн тооллоор] шинэ оныг угтахдаа “нийтээр хэчнээн хугацаанд амардаг” -ийг жишиж тодруулахад оршино.

## **ЦАГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН, БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА**

<i>Судалгааны код:</i>	СТ-13/222
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Р.Оргилмаа
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Г.Уянга
<i>Сэдвийн агуулга:</i>	Цагийн хөдөлмөр бий болгох хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хир зэрэг байгаа болон цагийн хөдөлмөрийн хууль батлагдвал ажилгүйдлийг багасгах бодит бололцоо байгаа эсэх, мөн ХБНГУ болон, БНСУ зэрэг цагийн хөдөлмөрийн зах зээл сайн хөгжсөн бусад орнуудын туршлагын талаар” харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэв.

## **АРХИНЫ ЭСРЭГ ТЭМЦЛИЙН АРГА ТАКТИК, ДЭЛХИЙН ТУРШЛАГА**

<i>Судалгааны код:</i>	СТ-13-224
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	Г.Чулуун, Д.Батдорж
<i>Захиалагч:</i>	УИХ-ын гишүүн Л.Эрдэнэчимэг
<i>Огноо:</i>	2013.06.11
<i>Сэдвийн агуулга:</i>	Архидалттай тэмцэх чиглэлд хүн төрөлтний олж хуримтлуулсан түүхэн туршлага, газар газрын улс үндэстэнд хэрэгжүүлж ирсэн эрт эдүгээгийн олон “хуурай хууль”-ийн агуулгын онцлогийг тодруулсан харьцуулсан судалгаа юм. (Нийт 17 хууд.) Архины асуудал бол дан ганц архины асуудал биш юм. Уг судалгаанд, <ul style="list-style-type: none"><li>- Архидан согтуурахын эсрэг улс бүхний өрнүүлсэн, өрнүүлэх бодлого тэмцэл хоорондоо ижилгүй, тийм байх үндэсгүй;</li><li>- Архины “нийгмийн аюулыг тэглэх нэгдсэн жор”-ыг өнөө болтол олдоогүй;</li><li>- Архины эсрэг үзлийг хүний мөн чанараас салангид авч үзэж, жишээ нь, үндэслэлгүйгээр үнийг нь хэт нэмэх нь нийгмийн ядуу хэсгийг улам ядууруулах аюултай, зөв биш алхам болохыг;</li><li>- Уламжлалт заншил ёсыг [зөөлөн, аажмаар] халж журамлах нь нийгмийг архидалтаас ангижруулах үйлсэд дэм өгдөг; ... гэх мэтээр тухайн асуудлыг олон аспектаар баримт жишээтэйгээр харьцуулжээ.</li></ul>

## **ЗАЛУУ ГЭР БҮЛИЙГ ДЭМЖИХ ТӨРИЙН БОДЛОГЫН ТАЛААР БУСАД ОРНЫ ЗОХИЦУУЛАЛТ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ АСУУДАЛ**

<i>Судалгааны код:</i>	СТ-13/225
<i>Судалгааны төрөл:</i>	Харьцуулсан судалгаа
<i>Гүйцэтгэсэн судлаач:</i>	П.Нарантуяа
<i>Захиалагч:</i>	Улсын Их хурлын гишүүн Л.Энх-Амгалан
<i>Огноо:</i>	2013.06.12
<i>Сэдвийн агуулга:</i>	Энэхүү судалгаанд АНУ, Их Британи, Франц, Швед, ОХУ, Хятад зэрэг улсуудад “Залуу гэр бүл”-ийг дэмжих талаар гарсан хууль тогтоомж, Төрөөс нь үзүүлж буй бодлого, нийгмийн халамжийн тэтгэмжийн талаарх мэдээллийг цуглуулав. Монгол Улсын төрөөс

залуу гэр бүлийн талаар авч явуулж байгаа бодлого түүний үр дүн, статистик үзүүлэлт, судлаачдын гаргасан зөвлөмж, залуучуудын талаар цаашид аль асуудалд илүү анхаарал төвлөрүүлэх шаардлагатай талаар судалгаанд оруулав. Нөгөө талаар Гэр бүл гэсэн нэг цогц ойлголтоор асуудалд хандах нь чухал болохыг судалгааны явцад ажиглагдлаа.

#### **АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖ, АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛ БОЛОН АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА**

*Судалгааны код:* СТ-13/226  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Д.Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаг  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан  
*Огноо:* 2013.06.18  
*Сэдвийн агуулга:* Уг судалгаагаар бусад улс оронд ажилгүйдлийн тэтгэмж олгодог туршлага, ажилгүйдлийн даатгал болон ажилгүйдлийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн эрх зүйн зохицуулалтыг харуулахыг зорилгоо. Судалгаанд ажилгүйдлийн даатгалын тогтолцоо өндөр хөгжсөн, ажилгүйдлийн тэтгэмж олгох систем нь нэлээд боловсронгуйд тооцогддог Канад, Япон, Чех, Франц зэрэг өндөр хөгжилтэй орнуудын ажил эрхлэлтийн даатгалын тогтолцоо, ажилгүйдлийн тэтгэмж олгох хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг нь харьцуулан судлав.

#### **ХҮҮХЭД ҮРЧЛҮҮЛЭХ БОЛОН ХҮҮХЭД ҮРЧЛЭН АВАХ ТАЛААР БУСАД ОРНЫ ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-13/230  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Референт П.Нарантуяа  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан  
*Огноо:* 2013.07.08  
*Сэдвийн агуулга:* Хүүхэд үрчлэх тухай асуудал бол маш нарийн зохицуулалт шаардсан хүний эрх, ялангуяа хүүхдийн эрхийг хөндсөн асуудал учраас насанд хүрээгүй хүн өөрийгөө хамгаалах чадваргүй байгааг онцгой авч үзэн хүүхдийн эрхийг дээдлэх зарчмыг асуудлын гол болгон авч үздэг. Судалгаанд Олон улсын конвенц, тунхаглалаас гадна гадаадын 11 улсууд /Франц, БНСУ, Швед, БНХАУ, Бельги, ОХУ, Герман, Япон, Вьетнам, Англи, АНУ/ болон Монгол Улсын хүүхэд үрчлүүлэх болон үрчлэн авах асуудлыг судалж дүгнэлт хийлээ.

#### **ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, НИЙГМИЙН ХЭВ ЖУРМЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-13/234  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, А.Пагма  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Ж.Батзандан

**Огноо:** 2013.10.03  
**Сэдвийн агуулга:** Нийгмийн тогтсон хэм хэмжээний эсрэг үйлдлийн эрх зүйн зохицуулалтыг Их Британи, Латви, Украин улс, олон нийтийн аюулгүй байдлын талаарх эрх зүйн зохицуулалтыг АНУ, ОХУ-ын жишээн дээр харьцуулан авч үзсэн ба ХБНГУ, АНУ зэрэг олон улсад олон нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангахад иргэдийн оролцоог чухалчлан үзэж зарим улсад хууль, эрх зүйн актаар баталгаажуулдаг талаар мэдээллийг бэлтгэв.

### **ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮДИЙН ЦАЛИН ХӨЛС, ХАНГАМЖИЙН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

**Судалгааны код:** СТ-13/235  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Ц.Болормаа  
**Захиалагч:** Захиргаа, нийтлэг үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн дарга Б.Цэвээнпүрэв

**Огноо:** 2013.10.10.  
**Сэдвийн агуулга:** Тус судалгаанд Австрали, ОХУ, Энэтхэг, Шинэ Зеланд, АНУ, Их Британи, Канад, Финланд, Грек, Япон зэрэг улс оронд Парламентын гишүүнд хууль тогтоох, төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлснийх нь төлөө олгож буй цалин бусад хангамжийг ямар эрх зүйн орчны хүрээнд ямар хэмжээгээр хэрхэн тогтоож байгаа талаар харьцуулан судалсан болно.

### **АМАРЖСАН ЭХЧҮҮДЭД ҮЗҮҮЛДЭГ НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУРШЛАГА ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ГАЗРЫН ТОСНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

**Судалгааны код:** СТ-13/240  
**Судалгааны төрөл:** Харьцуулсан судалгаа  
**Гүйцэтгэсэн судлаач:** Р.Хатанбаатар, А.Пагма, Ө.Мөнхтунгалаг  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл  
**Огноо:** 2013.12.06  
**Сэдвийн агуулга:** Гэр бүлийн талаар баримтлах бодлогын нэг чухал хэсэг болох жирэмсэн эмэгтэйчүүд, амаржсан эх, нялхсыг хамгаалах, тэтгэмж, тусламж үзүүлэх, хүүхэдтэй гэр бүлд хөнгөлөлт үзүүлэх халамж, үйлчилгээний талаар гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт, туршлагын талаар мэдээллийг бэлтгэв.

### **ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛДЭГ ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА**

**Судалгааны код:** СТ-13/408  
**Судалгааны төрөл:** Лавлагаа, мэдээлэл  
**Гүйцэтгэсэн судлаач:** А.Пагма  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн С.Оюун  
**Огноо:** 2013.04.23  
**Сэдвийн агуулга:** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь мөн л бусад хүүхдийн нэгэн адил эрхтэй, нийгэм хэмээх гэр бүлийн гишүүн бөгөөд гагцхүү тэд тусгай хэрэгцээтэй гишүүд юм. Гэвч тэдний ихэнх нь хувийн болон



нийгмийн шалтгаанаар бусдын нэгэн адил хөгжих боломж нь хязгаарлагдмал байдаг тул нийгмийн амьдралын бүхий л хүрээнд тэдэнд тусгай анхаарал халамж, хамгаалал шаардлагатай байдаг. Бидний судалгааны явцад цуглуулсан мэдээлэл, эх сурвалжийг үндэслэн Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй 16 нас хүртэлх хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг улсын болон хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын талаарх лавлагааг дараах байдлаар хүснэгтээр үзүүлье.

### **УИХ-ЫН 2012 ОНД БАТЛАГДСАН “АЖИЛЛАСАН ЖИЛ, ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТООЦОХ ТУХАЙ” ХУУЛИЙН ЗААЛТАД ХАМРАГДААГҮЙ “ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ ИРГЭДИЙГ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛЭЭ САЙН ДУРААР НӨХӨН ТӨЛСНӨӨР, ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БИЙ БОЛГОХ АСУУДАЛ”**

**Судалгааны код:** СТ-13/409  
**Судалгааны төрөл:** Лавлагаа, мэдээлэл  
**Гүйцэтгэсэн судлаач:** П.Нарантуяа  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Г.Уянга  
**Огноо:** 2013.05.01  
**Сэдвийн агуулга:** Монгол Улсын хууль, хуультай холбогдон гарсан журамд Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн заалтад хамрагдаагүй “хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг нийгмийн даатгалын шимтгэлээ сайн дураар нөхөн төлснөөр, тэтгэвэр тогтоолгох эрх зүйн орчныг бий болгох асуудал”-ыг хэрхэн шийдвэрлэж байгаа, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд сайн дурын даатгалын тухай, сайн дурын даатгалд хамрагдаагүй иргэнийг нийгмийн даатгалын шимтгэлээ нөхөн төлж нийгмийн даатгалд хамрагдах боломж байгаа эсэх, боломжгүй бол эрх зүйн орчныг бий болгох асуудал арга замын талаар лавлагаа болон энэ хуульд хамрагдах иргэдийн тоо, төсөвт оруулах боломжтой орлого, учирч болох эрсдэлийн талаар судалгаа хийлгэхийг хүссэний дагуу уг асуудлыг судлан холбогдох мэдээлэл лавлагааг гаргасан. н мэдээлэл өгөхөд оршино.

### **ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ИЖИЛ ХҮЙСТНИЙ ГЭРЛЭЛТИЙН ЭРХ ЗҮЙН СТАТУС, ИЖИЛ ХҮЙСТЭН ХОСУУДЫН ХҮҮХЭД ҮРЧИЛЖ АВАХ АСУУДЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА**

**Судалгааны код:** СТ-13/413  
**Судалгааны төрөл:** Лавлагаа, мэдээлэл  
**Гүйцэтгэсэн судлаач:** А.Пагма  
**Захиалагч:** УИХ-ын гишүүн Ж.Батзандан  
**Огноо:** 2013.06.28  
**Сэдвийн агуулга:** Гадаадын 39 орны ижил хүйстний гэрлэлт, ижил хүйстний бусад харилцааны эрх зүйн статус, хууль тогтоомжоор тэдэнд олгогдсон эрхийн лавлагааг гарган, ижил хүйстэн хосуудын хүүхэд үрчилж авах асуудлын эрх зүйн зохицуулалт, энэ асуудлаарх зарим статистик тоо баримтын талаар энэхүү мэдээлэл, лавлагааг бэлтгэв.

## **ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨХ САРЫН ОРЛОГЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ ТОГТООХТОЙ ХОЛБОГДСОН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-13/419  
*Судалгааны төрөл:* Харьцуулсан судалгаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, А.Пагма  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Р.Бурмаа  
*Огноо:* 2013.10.08  
*Сэдвийн агуулга:*

Нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын орлогын дээд хэмжээг тогтоохтой холбогдсон хууль, эрх зүйн зохицуулалт, сарын орлого, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ, нийгмийн даатгалын суурь үнэ, түүнийг тогтоодог байгууллагын талаар Швед, Норвеги, Их Британи, Австри, ОХУ-ын жишээн дээр мэдээллийг бэлтгэв.

## **ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ОЛОН НИЙТИЙН ТЕЛЕВИЗИЙН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГАД ХЯНАЛТ ТАВИХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-13/420  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Ө.Мөнхтунгалаг  
*Захиалагч:* УИХ-ын даргын зөвлөх З.Нарантуяа  
*Огноо:* 2013.10.09  
*Сэдвийн агуулга:*

Монгол Улсын олон нийтийн телевизийн сувгуудаар бусад орны соёл, зан заншил, ёс суртахууныг харуулсан олон ангит киног байнгын давтамжтайгаар гаргаж байгаа нь хүүхэд залуучуудын оюун санаа, зан суртахуунд нөлөөлж байна гэсэн шүүмжүүд олон нийтийн дунд түгээмэл байдаг тул бусад орнуудын олон нийтийн телевизүүд гадаадын кино, нэвтрүүлгийн эфирийн цагт эзлэх хувь хэмжээг хуульчлан тогтоодог эсэх, хэрвээ тогтоодог бол ямар хяналт, зохицуулалттайгаар энэ асуудлыг шийдвэрлэдэг талаарх туршлагыг харьцуулан судалсан.

## **АНУ-Д АЖИЛЛАЖ АМЬДАРЧ БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД ТУХАЙН УЛСЫН НИЙГМИЙН ДААТГАЛД ХАМРАГДСАН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА**

*Судалгааны код:* СТ-13/421  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, А.Пагма  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн С.Эрдэнэ  
*Огноо:* 2013.10.15  
*Сэдвийн агуулга:*

АНУ-ын татварын тогтолцоо, нийгмийн ба эрүүл мэндийн даатгалын талаар болон мөн АНУ-д албан ёсоор ажиллаж, амьдарч, сурч байгаа бүх хүн, түүний дотор гадаадын иргэд ч ажил хийхдээ Social Security Number (SSN) буюу нийгмийн даатгалын дугаар авсан байх ёстой бөгөөд энэ нь тухайн хүн хууль ёсны үндсэн дээр ажиллаж байгаагийн баталгаа болж, ажил олгогчоос ажиллагсдын хөдөлмөрийн хөлснөөс татвар суутгахад хэрэглэгддэг талаар мэдээлэл бэлтгэсэн.

## **ОХУ-ЫН ТЭТГЭВЭР, НИЙГМИЙН ДААТГАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЧИГ ҮҮРЭГ, ЭРХ ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

*Судалгааны код:* СТ-13/423  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, А.Пагма  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ  
*Огноо:* 2013.10.28  
*Сэдвийн агуулга:*

Гэр бүлийн талаар баримтлах бодлогын нэг чухал хэсэг болох жирэмсэн эмэгтэйчүүд, амаржсан эх, нялхсыг хамгаалах, тэтгэмж, тусламж үзүүлэх, хүүхэдтэй гэр бүлд хөнгөлөлт үзүүлэх халамж, үйлчилгээний талаар гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт, туршлагын талаар мэдээллийг бэлтгэв.

## **ЭХ НЯЛХАСЫН ХАЛАМЖИЙН АГУУЛГАТАЙ [МАНАЙ] ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

*Судалгааны код:* СТ-13/424  
*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа  
*Гүйцэтгэсэн судлаач:* Г.Чулуун  
*Захиалагч:* УИХ-ын гишүүн С.Дэмбэрэл  
*Огноо:* 2013.12.10  
*Сэдвийн агуулга:*

Нийгмийн халамж нь хүн амын эмзэг хэсэгт хамаарах .. эх, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, нэн ядуу амьдралтай иргэнд тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр тэдний амьжиргааг дээшлүүлэх, түүнчлэн хүүхэд төрүүлсэн эх, бүтэн өнчин хүүхэд үрчилж авсан гэр бүл, ихэр хүүхдэд тэтгэмж олгох [улсаас харж үзэх] нийгмийн хамгааллын арга хэмжээ юм.

Амаржсан эхийн тэтгэмж нь эхийн урамшууллын хүрээнд хөндөгддөг бүлэг асуудлын нэг төрөл, явцуу агуулгатай сэдэв юм. Захиалагчийн хүсэлтэд “амаржсан эхчүүдэд үзүүлж ирсэн халамж хангамж, тэтгэмж тусламж” –ийн талаар тухайлж заасан учраас, асуудлыг бид “амаржсан эх” ухагдахууны хамаарах тэр зурвас хугацаанд хэрэгжих арга хэмжээгээр хязгаарлахыг эрмэлзэв. “Амаржсан эх” ойлголтын хүрээнд хамаарах хугацаа хэзээ эхэлдэг нь тодорхой ч хэзээ дуусдаг нь зарим талаар маргаантай байна.

Хууль тогтоомжийн агуулга дахь “жирэмсэн эх”, “амаржсан эх” нэр томъёо хоорондоо мэдээж утгын ялгамжтай ч, нийлээд, тухайн эхийн үрээ тээж төрүүлэх, хөхүүлж торниулах бүтэн циклийн хугацааг дам илэрхийлж, “жирэмсэн, хөхүүл эх, нярайн” гэсэн агуулга тодотголтой нийгмийн хамгааллын бусад арга хэмжээтэй цаг хугацааны хувьд үндсэндээ давхцдаг. Тиймээс нөхөн үржихүйн давтамжит циклийн .. мөчлөгт хамаарах тэтгэмж тусламжийн талаар; гэх маягаар асуултыг өргөтөн ярих хэрэгцээ заримдаа гардаг. Лавлагаанд, эх нялхаст анхаарал халамж тавьж ирсэн [монголын] нийгмийн түүх уламжлалын болон өнөөгийн бодит байдлын талаарх мэдээллийг оруулав.

**ГАДААДЫН ЗАРИМ УЛС ДАХЬ ХУУРАМЧ ЭМИЙН ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ БОЛОН ХУУРАМЧ ЭМИЙН ЭРГЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

*Судалгааны код:* СТ-13/427

*Судалгааны төрөл:* Мэдээлэл лавлагаа

*Гүйцэтгэсэн судлаач:* Р.Хатанбаатар, Г.Чулуун, А.Пагма, Ө.Мөнхтунгалаг

*Захиалагч:* УИХ-ын гишүүн Г.Баярсайхан

*Огноо:* 2013.12.12

*Сэдвийн агуулга:*

Захиалгын дагуу Medicrime конвенцийн талаарх мэдээлэл, ОХУ, БНХАУ, АНУ, БНКазУ, Украин улсууд дахь хуурамч эмийн худалдаа, үйлдвэрлэл, хуурамч эмийн эргэлтийн талаар болон эдгээр улсуудад хуурамч эмийн үйлдвэрлэл, худалдааны эсрэг ямар хууль, тогтоомж үйлчилдэг талаар мэдээллийг бэлтгэв. Мөн Монгол Улс дахь хуурамч эмийн талаарх мэдээлэл, хуурамч эм хэрэглэснээс хүний амь нас эрсэдсэн эсэх тухай Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Монгол Улсын Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн мэдээллийг хавсаргав.